

## ХУРАЛДААНЫ ТОЙМ

### ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН 2016 ОНЫ ХОЁР ДУГААР ХУРАЛДААН

Хуралдаан 2016 оны нэгдүгээр сарын 14-ний 14 цаг 15 минутад эхэлж, 15 цаг 39 минут хүртэл Төрийн албаны зөвлөлийн хуралдааны танхим (Засгийн газрын 11 дүгээр байрны 301 тоот өрөө)-д болж, нийт 1 цаг 34 минут үргэлжлэв.

№	Хэлэлцсэн асуудал	Гарсан шийдвэр
1	Эрчим хүчний яамны Хяналт, шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын даргын албан тушаалд томилуулахаар Төрийн албаны зөвлөлийн дүгнэлт гаргаж, нэр дэвшүүлэх тухай	<p>Төрийн албаны тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1, 35 дугаар зүйлийн 35.1.6 болон Улсын Их Хурлын 2003 оны 13 дугаар тогтоолоор баталсан “Төрийн жинхэнэ албаны удирдах албан тушаалд томилогдох ажилтныг сонгон шалгаруулах журам”-ын 14-ийн “а”-д заасныг тус тус баримталж, төрийн жинхэнэ албаны удирдах албан тушаалд томилогдох ажилтныг сонгон шалгаруулах комиссын 02 дугаар дүгнэлтийг үндэслэн Төрийн албаны зөвлөлийн 2016 оны 01 дүгээр сарын 14-ний өдрийн хуралдаанаас:</p> <p>Баатарын Сандуйжавыг Эрчим хүчний яамны Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын даргын албан тушаалд томилуулахаар нэр дэвшүүлж, Эрчим хүчний яамны Төрийн нарийн бичгийн дарга Д.Дэлгэрцогтод санал болгох тухай Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн тогтоол гаргахаар тогтов.</p>
2	УИХ-ын Тамгын газрын Мэдээлэл, үйлчилгээ, удирдлагын төвийн даргын албан тушаалд томилогдох удирдах ажилтны ажлын байрыг нийтэд, нээлттэй зарлах тухай	<p>УИХ-ын Тамгын газрын Мэдээлэл, үйлчилгээ, удирдлагын төвийн даргын албан тушаалд томилогдох удирдах ажилтны ажлын байрыг нийтэд, нээлттэй зарлахыг хойшлуулахаар шийдвэрлэв.</p>
3	Говьсүмбэр аймгийн ИТХ-ийн Тэргүүлэгчдийн нарийн бичгийн даргын албан тушаалд томилогдох удирдах ажилтны ажлын байрыг нийтэд, нээлттэй зарлах тухай	<p>Говьсүмбэр аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга Г.Батсуурь 2016 оны нэгдүгээр сарын 08-ны 10 тоот албан бичгээр тус аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн даргын албан тушаалд томилогдох удирдах ажилтны нээлттэй сонгон шалгаруулалт зарлуулах захиалга ирүүлснийг хэлэлцээд,</p>

		сонгон шалгаруулалтыг 2016 оны нэгдүгээр сарын 14-нөөс Төрийн албаны зөвлөлийн цахим хуудсаар нийтэд нээлттэй зарлаж, сонгон шалгаруулалтыг 2016 оны хоёрдугаар сарын 16-нд зохион байгуулахаар шийдвэрлэв.
4	Төрийн албаны зөвлөлийн 2015 оны 209 дүгээр тогтоолын зургаадугаар хавсралтад өөрчлөлт оруулах тухай	<p>“Төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэний нөөцөд бүртгэж, нэр дэвшүүлэх тухай” 2015 оны 12 дугаар сарын 03-ны өдрийн 209 дүгээр тогтоолын 6 дугаар хавсралтад өөрчлөлт оруулах тухай асуудлыг хэлэлцсэн Төрийн албаны зөвлөлийн 2016 оны 01 дүгээр сарын 14-ний өдрийн хуралдааны шийдвэрийг үндэслэн:</p> <p>1. Төрийн албаны зөвлөлийн “Төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэний нөөцөд бүртгэж, нэр дэвшүүлэх тухай” 2015 оны 12 дугаар сарын 03-ны өдрийн 209 дүгээр тогтоолын 6 дугаар хавсралт “Туслах түшмэлийн ангиллын төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэний нөөцийн жагсаалт”-ын 89 дэх хэсгийг хавсралтад дурдсанаар өөрчлөх тухай Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн тогтоол гаргахаар тогтов.</p>
5	Төрийн албаны зөвлөлийн Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын яамны дэргэдэх Салбар зөвлөлийн нарийн бичгийн даргыг томилох тухай	<p>Улсын Их Хурлын 2009 оны 87 дугаар тогтоолоор баталсан “Төрийн албаны зөвлөлийн үйл ажиллагааны дүрэм”-ийн “Гурав”-ын 3.3, Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын яамны дэргэдэх салбар зөвлөлийн даргын 2016 оны 01 дүгээр сарын 06-ны өдрийн 02 тоот албан бичгээр ирүүлсэн хүсэлт, Төрийн албаны зөвлөлийн 2016 оны 01 дүгээр сарын 14-ний өдрийн хуралдааны шийдвэрийг үндэслэн:</p> <p>1. Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын яамны Төрийн захиргааны удирдлагын газрын Хүний нөөцийн асуудал хариуцсан мэргэжилтэн Жавхаагийн Амаржингуаг 2016 оны 01 дүгээр сарын 14-ний өдрөөс эхлэн Төрийн албаны зөвлөлийн тус яамны дэргэдэх Салбар зөвлөлийн нарийн бичгийн даргаар томилох</p> <p>2. Төрийн албаны зөвлөлийн 2013 оны 131 дүгээр тогтоолын 2 дугаар хавсралтын “Нэг”-ийн 13-ын “Нарийн бичгийн дарга-Төрийн захиргаа удирдлагын</p>

		<p>газрын Захиргаа, хүний нөөцийн асуудал хариуцсан ахлах мэргэжилтэн Гочоогийн Нарангэрэл " гэсэн хэсгийг хүчингүй болгох</p> <p>3. "Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн ажиллах журам"-д заасан чиг үүргийг хууль тогтоомжийн хүрээнд бүрэн хэрэгжүүлж ажиллахыг Салбар зөвлөлийн нарийн бичгийн дарга Ж.Амаржингуад үүрэг болгох тухай Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн тогтоол гаргахаар тогтов.</p>
6	Төрийн албаны зөвлөлийн Иргэний харьяалал, шилжилт хөдөлгөөний ерөнхий газрын дэргэдэх Салбар зөвлөлийн даргыг томилох тухай	<p>Улсын Их Хурлын 2009 оны 87 дугаар тогтоолоор баталсан "Төрийн албаны зөвлөлийн үйл ажиллагааны дүрэм"-ийн 3.3, Засгийн газрын 2015 оны 525 дугаар тогтоол, Төрийн албаны зөвлөлийн 2016 оны 01 дүгээр сарын 14-ний өдрийн хуралдааны шийдвэрийг үндэслэн :</p> <p>1. Төрийн албаны зөвлөлийн Иргэний харьяалал, шилжилт хөдөлгөөний ерөнхий газрын дэргэдэх салбар зөвлөлийн даргаар тус агентлагийн дарга Дондивын Болдыг 2016 оны 01 дүгээр сарын 14-ний өдрөөс эхлэн томилох</p> <p>2. Төрийн албаны зөвлөлийн 2013 оны 131 дүгээр тогтоолын 2 дугаар хавсралтын "Хоёр"-ын 7-ын "... Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн дарга-тус агентлагийн дарга Бөхчулууны Пүрэвдорж" гэсэн хэсгийг хүчингүй болгох</p> <p>3. "Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн ажиллах журам"-д заасан чиг үүргийг хууль тогтоомжийн хүрээнд бүрэн хэрэгжүүлж ажиллахыг Салбар зөвлөлийн дарга Д.Болдод үүрэг болгох тухай Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн тогтоол гаргахаар тогтов.</p>
7	Төрийн албаны зөвлөлийн зарим Салбар зөвлөлийг татан буулгах тухай	<p>Төрийн албаны тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.3, "Засгийн газрын агентлаг, төрийн байгууллагуудын бүтэц, зохион байгуулалтын талаар авах зарим арга хэмжээний тухай" Засгийн газрын 2015 оны 501 дүгээр тогтоол, Улсын Их Хурлын 2009 оны 87 дугаар тогтоолоор баталсан "Төрийн албаны зөвлөлийн үйл ажиллагааны дүрэм"-ийн 3.3, 4.4.дэх хэсгийг тус тус баримтлан, Төрийн албаны зөвлөлийн 2016 оны 01 дүгээр сарын 14-</p>

		<p>ний өдрийн хуралдааны шийдвэрийг үндэслэн:</p> <p>1. Татварын ерөнхий газар, Гаалийн ерөнхий газар, Улсын бүртгэлийн ерөнхий газар, Үндэсний статистикийн хороо, Төрийн өмчийн хорооны дэргэдэх Салбар зөвлөлийг 2016 оны 01 дүгээр сарын 14-ний өдрөөс эхлэн тус тус татан буулгах</p> <p>2. “Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн бүрэлдэхүүнийг батлах, дарга, нарийн бичгийн дарга нарыг томилох тухай” Төрийн албаны зөвлөлийн 2013 оны 131 дүгээр тогтоолын 1 дүгээр хавсралтын “Хоёр”-ын 7, 9, 10, 11 дэх хэсэг, мөн тогтоолын 2 дугаар хавсралтын “Хоёр”-ын 4, 9, 10, 11 дэх хэсэг, “Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийг байгуулах, салбар зөвлөлийн бүрэлдэхүүнийг батлах тухай” Төрийн албаны зөвлөлийн 2014 оны 27 дугаар тогтоол, “Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн дарга, нарийн бичгийн даргыг томилох тухай” Төрийн албаны зөвлөлийн 2014 оны 28 дугаар тогтоол, Төрийн албаны зөвлөлийн даргын 2015 оны 25 дугаар тушаалын хавсралтаар баталсан “Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн яам, агентлагийн болон аймаг нийслэл дэх салбар зөвлөлийн үйл ажиллагаанд хэрэглэх тэмдэгний жагсаалт”-ын 38, 45, 46, 48, 51-ийг тус тус хүчингүй болгох</p> <p>3. ”Татан буулгасан салбар зөвлөлүүдийн үйл ажиллагаанд хэрэглэж байсан “Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөл”-ийн 34 /ТӨХ/, 45 /ТатЕГ/, 46 /ГЕГ/, 51 /УБЕГ/, 60 /ҮСХ/ дугаартай тэмдгүүдийг хураан авч, холбогдох бичиг, баримтуудыг Архивын хуулийн дагуу байгууллагын архивт хүлээлгэн өгөх ажил зохион байгуулахыг Төрийн албаны зөвлөлийн Ажлын алба /С.Цэдэндамба/-нд даалгах тухай Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн тогтоол гаргахаар тогтов.</p>
8	Хууль Сахиулахын Их Сургуулийн дэргэд Төрийн албаны зөвлөлийн Салбар зөвлөл байгуулах шаардлага, эрх зүйн үндэслэлийг судалсан Ажлын хэсгийн дүгнэлт танилцуулах	Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийг Хууль сахиулахын их сургуулийн дэргэд байгуулах шаардлага, эрх зүйн үндэслэлийг судалсан Ажлын хэсгийн “Төрийн албаны зөвлөлийн дүрэм”-ийн 1.1-д “...яам, агентлаг, аймаг, нийслэлийн хэмжээнд ажиллах Төрийн албаны

		зөвлөлийн зохион байгуулалтын бүтцийн салбар нэгж мөн. гэж заасан эрх зүйн зохицуулалттай нийцэхгүй байгаа тул Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийг тус сургуулийн дэргэд байгуулах боломжгүй” гэсэн дүгнэлтийг зүйтэй гэж үзэв.
--	--	--

**ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН АЖЛЫН АЛБА**